

**“Далан тоть”-ийн үлгэрийн
монгол аман хувилбар**

Р.Чүлтэмсүрэн

1. Оршил

Эртний Энэтхэгийн "Далан тотийн үлгэр" (Шукаса'тати) хэмээх зохиол дэлхийн уран зохиолд нэн алдартай билээ. Энэ үлгэрийн гол өгүүлэмж нь: Худалдаачны хүү Мадана алс хол оронд худалдаа хийхээр явсан хойгуур гэргий нь өөр эртэй шалиглан зугаалах гэхэд нь цэцэн тоть үдэш бүр нэг үлгэр хэлж, гадагш эс гарган, гэрт нь унтуулж чадаж байгаа тухай олон үлгэрийн цоморлиг юм.

Эдгээр үлгэрээс бичгийн зохиолд санаа авч, адил өгүүлэмжтэй өөр үлгэрийг шинээр зохиох болсон байна. Тийм үлгэрүүд санскрит, төвд, перс, урду, монгол хувилбараар уламжлагдан иржээ. Уг зохиолын дэлгэрэлт, уламжлал, шинэчлэл зэргийг эрдэмтэд бичгийн зохиолын хүрээнд илүүтэй судалсан байна.

Харин бид энэ зохиолыг аман ба бичгийн, бичгийн ба аман зохиолын харьцаа холбоонд нь зарим нэг ажиглалт хийхийг оролдож, монгол аман хувилбаруудыг тогтоох зорилго тавьсан юм.

2. “Далан тотийн үлгэр”-ийн бичгийн хувилбарууд

Уг зохиолын бичгийн хувилбарууд Энэтхэг, Төвд, Перс, Монгол зэрэг орны уран зохиолд түгээмэл байна. “Далан тотийн үлгэр” зохиолын өгүүлэмж, дүр хэрхэн уламжлагдаж байсныг товч дурдвал:

1. Энэтхэг хувилбар:

“Далан тотийн үлгэр”-ийн 9-р үлгэр нь Рашааны дуслын тайлбар Эрдэнийн чимэг зохиолын Наяа бярмань үлгэртэй төстэй, 31-р үлгэр нь Мэргэн туулай арсланг алсан үлгэртэй төстэй, 50-р үлгэр нь Субашидийн 149-р бадагт Цахар гэвшийн хийсэн тайлбарын доторхи тэнэг хүн олсон алтаа цэцэн нөхөртөө үзүүлж булсан үлгэртэй төсөөтэй¹ гэж үздэг юм.

¹ Ц.Дамдинсүрэн, *Монголын уран зохиолын тойм*. УБ., 1976, 350.

Уг зохиолыг ийнхүү Энэтхэгийн бичгийн уран зохиолд дууриал болгон боловсруулж байсан уламжлал, туршлага хөгжлийн явцад хүрээгээ тэлж, бусад орны уран зохиолд тодорхой нөлөөлөн, биеэ даасан бичгийн хувилбарууд бүрэлдэн тогтжээ.

2. *Төвд хувилбар:*

Арван нэгдүгээр зууны үед зохиогдсон төвдийн Хөвгүүн номын дотор байгаа Арван гурван шатны үлгэрийн хэлхээ “Далан тотийн үлгэр”-ийн хэлхээтэй адил юм. Хөвгүүн номын доторхи үлгэрт худалдаачин далайн аянд явахдаа эхнэрээ ороолон, тогь хоёроор сахиулан үлдээнэ. Тогь 13 шөнө үлгэр хэлж, эхнэрийг саатуулна. Ийм өгүүлэмж, үлгэрийг хэлхсэн арга, хэлбэр нь Шукаса’татийн үлгэртэй адил байна.

Гэвч “Хөвгүүн номын 13 үлгэртэй адил нэг ч үлгэр Энэтхэгийн тотийн үлгэрийн дотор байхгүй байна. Үүнээс үзвэл хэлбэрийн хувьд төстэй болохоос бус агуулгын хувьд огт өөр үлгэрийн цоморлиг байна² гэж үздэг.

3. *“ерс хувилбар:*

Арван дөрөвдүгээр зуунд “Зия-уд Нахшабийн зохиосон ‘ерс хэлний Тути наме утгаа санскрит хэлний “Далан тотийн үлгэр”-ээс гаралтай боловч зарим үлгэрийг нэмж хассан ба бүх үлгэрийг их өөрчлөн хувиргасан байдаг³ ажээ.

4. *Урду хувилбар:*

Арван наймдугаар зуунд Энэтхэгийн зохиолч Хайдар Бахша Хайдарын эмхэтгэсэн урду хэлний Тота кахани (тотийн 38 үлгэр) хэмээх зохиол *ерс хэлний Тути наме номоос уламжлалтай. Гэхдээ санскрит хэлний тотийн далан үлгэрээс урду хэлний тотийн 38 үлгэр нь их өөр бөгөөд уран саналга, найруулгаар үлэмжхэн боловсорсон байна. Харин урду хэлний 38 үлгэр нь Субашид, Арж Борж хааны намтар, Шидэт хүүрийн үлгэрийн зарим үлгэртэй төстэй буйг академич Ц.Дамдинсүрэн тэмдэглэсэн байдаг.

5. *Монгол хувилбар:*

“Далан тотийн үлгэр”-ийн 66-р үлгэр нь монгол Арж Борж хааны намтарын (Гучин хоёр модон хүний үлгэрийн) доторхи анч өвгөний торонд орсон тотийн үлгэртэй төстэй байна гэж үздэг.

Мөн 27 бүлэгт төвд Шидэт хүүрийн үлгэрийн гар бичмэлд байсан Арван гурван гишгүүрийн үлгэрийг монгол хэлээр орчуулан хэвлүүлжээ. Ийнхүү “Далан тотийн үлгэр” голдуу Энэтхэг, Төвд хэлнээс орчуулсан монгол орчуулгын хувилбараар байна. Харин уг зохиол монголын бичгийн уран зохиолд өгүүлэмж зэрэг бүрэн хэлбэрээрээ уламжлагдаагүй бололтой байна. Зөвхөн Шукаса’тати зохиолоос уламжилсан төвд үлгэрийн монгол орчуулгын хувилбарыг үүсгээд тэр орчуулгаа Шидэт хүүрийн үлгэрийн нэг хувилбарын төгсгөлийн бүлэг болгож, биеэ даасан нэг зохиолын дотор ийнхүү өөр нэг зохиолыг нэмж, хажлага дотор бас нэг хажлага үүсгэж, үндсэн зохиолын утга, зохиомжийг дэлгэрүүлсэн нь анхаарал татаж байна.

² Ц.Дамдинсүрэн, 1976, 352.

³ Ц.Дамдинсүрэн, 1976, 352.

Эндээс харахад монголчууд уг алдарт зохиолыг эртнээс сайн мэддэг, орчуулгын олон хувилбараар боловсруулж байсан, бичиг үсэгтэн, бичгийн мэргэдийн хүрээнд илүүтэй түгж байсан нь тодорхой байна. Тэгвэл энгийн хүмүүс, хөдхө ард мэдэхгүй байсан уу гэвэл тийм биш ажээ. Чухам үүнийг батлахад ардын билиг зүй тусалж чадна.

3. “Далан тотийн үлгэр”-ийн монгол аман хувилбарууд

“Далан тотийн үлгэр”-ийн зарим өгүүлэмж, мэргэн тоть шувууны дүр монголд аман хувилбараар өргөн дэлгэрсэн байна. “Далан тотийн үлгэр”-ийн 43-р үлгэр нь Барыг айлгаж, чоныг чирж алуулсан монгол ардын үлгэртэй төстэй⁴.

Доктор Л.Хүрэлбаатар багшийн хувийн цуглуулганд гар бичмэлээр байсан Уран тотийн үлгэр (А), ардын билиг зүйч Даваасамбуугийн Дашдорж багшийн Монгол улсын Булган аймгийн Хишиг-Өндөр сумын иргэн 58 настай Д.Түмэндэлгэрээс тэмдэглэн авч хэвлүүлсэн Далан тотийн үлгэр (В), Ордосын Мэргэн тоть шувуу (С) зэрэг аман үлгэрүүдийн сэдэв, өгүүлэмж, мотив, дүр нь Шукаса’татийн үлгэртэй зарим талаар үнэхээр төстэй байгаа тул судалгааны хүрээнд оруулан, нэгтгэн харьцуулж ажиглая. Эхлээд өгүүлэмжийг нь товч ДУРДЪЯ.

А. Уран тотийн үлгэр:

1. Торонд орсон тотийн үлгэр (Аа. Т 233в)

Энэ үлгэрийн гол өгүүлэмж нь: Галбадрах хааны нүд гэнэт харанхуй болоход мэргэн зурхайч 71 тотийн аль нэгний тархийг идвэл хараа орно гэж гэнэ. Тэгээд таван зуун гуйлгачны хамгийн адгийн 13 настай хүүг тотийг олж ирвэл хаан суулгана, эс чадвал дүүжилнэ гээд явуулна. Хадан цохионы орой дахь үүрэнд нь тор тавихыг шувууны хаан тоть мэдэж нэг удаа нөхдөө аварна. Уран тотийн үгэнд тэд дахин эс орсон тул сүргээрээ баригдана. Маргааш нь уран тотийн зөвлөснөөр цөм торон дотроо үхсэн мэт хэвтэнэ. Хүү тотинуудыг үхэж гэж бодоод торноос нэг нэгээр авч шидлэхэд хатуужил тэсвэртэй байж дор бүрнээ тоолж 71 болохоор цөм зэрэг нисвэл аврагдах байлаа.

Гэтэл хүүгийн бүсэнд байсан билүү чулуу унахыг нэг тоонд авсан тул зэрэг дэрхийн нисэж торны мухарт байсан уран тоть ганцаар баригдана. Хүү нэг тоть авчир гэснээс бүгдийг авчир гэсэн биш гээд буцна. Замд цэцэн тоть хүүг ятган зүүн урагшаа Баян хааныд оч. Чи ядуу хүн тул мөнгө хэрэгтэй. Тэднийх хүний хэл мэддэг тоть хайж байгаа. Найман зуун алтан зоосноос намайг худалдаад хэдхэн сохор зоосоор азарган тахиа худалдан авч махыг нь идээд тархийг нь Галбадрах хаанд өгвөл нүд нь хараа орно гэж хэлнэ.

Хаан бүтэн тоть авчирсангүй тархи нь мөн юмуу гэхэд замдаа өлсөж харангадаад махыг нь идэж, тархийг нь авч ирлээ. Танд зөвхөн тархи нь хэрэгтэй шүү дээ гэж тотийн заасан үгийг хэлнэ. Үнэхээр хааны

¹¹ Ц.Дамдинсүрэн. 1975, 350.

нүд хараа орж, хүүг ар албатгүй өнцгийн сул хаан цол шагнаж алт, мөнгө, газар нутгаар шагнана. Энэ үлгэрийн хоёрдугаар хэсэг нь:

Хатныг саатуулагч тотийн үлгэрүүд:
(Аа.Т 243)

Хаан анд явахдаа тотид хандан:

-Хатан маань их завхай зайдам хүн. Үд болтол унтаж байгаад босч хотоор тэнэж хүн харахын аргагүй муухай амьтан үс гээгээ сэгсийлгэчихсэн архи дарс ханхлуулчихсан орж ирдэг. Гэрийн ажил гэж мэдэхгүй. Түүнийг гэрээсээ гаргахгүй байвал боллоо гэж захиана. Үнэхээр хатан үдэд сэрээд ерөөсөн ханцуйгаа өмсөж, бүсээ чирэн, гутлаа хам хум шургуулан, тэнэх гэхэд нь тоть доорхи үлгэрийг ярина.

(а) Сарангэрэл, Нарангэрэл хоёрын үлгэр

Баян Мөнхбадрах хаан Сарангэрэл гэдэг сайн түшмэл, Нарангэрэл хэмээх үзэсгэлэнт гүнжтэй ажээ. Сарангэрэл түшмэлийн гэргий нь хурмастын охин бөгөөд тэр гурван үедээ ханилж суух ёстой Нарангэрэл гүнж, Сарангэрэл түшмэл хоёрыг уран аргаар гэрлүүлж байгаа тухай энэ үлгэрт өгүүлнэ. Энэ үлгэрийг хатан амтархан сонсоод хаашаа ч явалгүй нар жаргааж, хаан ч ан аваас ирнэ. Тоть хатныг хаашаа ч явуулаагүй хэмээн хаанд сайрхан хэлэхийг далдаас сэм чагнасан хатан учрыг мэдэж хаанд гадуур явж явж сая ирлээ. Энэ чинь нэг муу аргат бор шувуу байна шүү дээ гэнэ. Хаан өөрийгөө хуурч мэхэллээ гээд тотийг алах гэсэнд тэр нэг үлгэр хэлнэ.

(в) Савсаг эхнэрийн үлгэр

Үзэсгэлэнт эм худгаас ус авах гэж байгаад алс тэртээ ууланд хэн нэгэн эр хосгүй сайхан дуулахыг сонсоод миний эр сайхан боловч ингэж дуулдаггүй. Энэ хичнээн сайхан эр бол гэж бодон санааширч, туслахаар ирсэн амраг ханиа худагт унаган орхиод дуу гарсан зүг яаран одно. Уул давааг давсаар очвол хулгана яр туссан гуйлгачин үхэхийн өмнө амь тэмцэн бахирч байсан нь хаданд цуурайтан дуу дуулж байгаа юм шиг сонсогдож байжээ. Ингэж сайн нөхрөө хаяж, үхлээ хүлээж байгаа хүн рүү гүйсэндээ сайхи эм гэмшин гутарч, хад руу нисэж үхэж гэнэ.

Гэнэн нь урьдаа гэмшил хойноо гэж хаанд тоть шувуу сануулан өгүүлнэ. Хаан үлгэрийг эс ойлгож дахин тотийг муужруулна. Тоть сэргээд бас дахин үлгэр хэлнэ.

(С) Ачитнаа хорлосон тухай үлгэр

Баатар эр элсэн цөлд ангаж цангаад модны дор сэрүүцэн хэвтэж байтал магнайд нь хүйтэн ус дусаж, аятай таатай байтал нэг хэрээ ирээд бахирна. Тэр хэрээ намайг үхэж гэж бодоод баярлаж байна гэж бодон харватал:

-Та дээшээ хараач хараач гээд хэрээ үхнэ. Тэр зүг харвал хорт могой хороо дусааж байсныг хэрээ далавчаа дэлгэн халхалж, амийг нь аварч байсныг тэр эр мэдэлгүй алсан байжээ. Хаан энэ үлгэрийн утгыг бас эс ухаарна.

Үлгэрийн төгсгөлд тоть муур, хулганатай нөхөрлөн, хааны бүтээсэн шинэ дуганд байрлан тэнхэрч, хаан хатан хоёрын үсийг зулгаалгаж өшөөгөө авна.

В. "Далан нэгэн тотийн үлгэр"

Далан нэгэн тотийн үлгэр (Д.Дашдорж 1976:176-177)-т:

Хааны хатан өвдөхөд эмч далан шувууны тархи идвэл эдгэнэ гэнэ. Хаан нэг ядуу урхич өвгөнд далан шувууны тархи олж ир. Эс олвол 70 лан төлнө шүү гэнэ. Өвгөн 71 тотийн хонодог хадан хавцгайг олж урхи тавихад ухаант улаан халзан тоть бусдыгаа удирдан хоногийн газар зайлан явна. Ухаант тотийн үгэнд нь ороогүй тул тэд баригдана. Өвгөн тэднийг тоолон чулуудахад нь шийдэм унаж, тотинууд зэрог нисэхэд ухаа халзан тоть баригдана. Өвгөн 70 тотийг алдсандаа уурлан үлдсэн тотийг алах гэхэд ухаант тоть: Та намайг 100 лангаар худалдаж, 70 лангий нь өрөндөө өгч, 30 ланг нь аминдаа ашигла гэж зөвлөнө. Өвгөн тотийн үгийг дагаж амар сайхан жаргана.

С."Мэргэн тоть шувуу"

Ордосын (Urdus-un amen öliгер 1990:174-178) энэ үлгэрт: Нэг баян айлын эргэн тойронд элдэв зүйлийн модтой бөгөөд 71 тоть тэнд нь үүрлэдэг гэнэ. Баяныд гүрэм хийж буй лам тоонон дээр нь суугаа тотийг хараад

Тоть шувуу тоонон дээр чинь суу
Тоот малыг чинь хулгай дага гэж хэлж байна.

Иймд ойр орчмынхоо тотийг хөөхгүй бол эд мал чинь барагдаж, өрх гэр чинь сүйднэ гэнэ. Баян тэр тотиудыг барихаар тор зангидаж тавина. 71 тоть дотор бас нэг ухаант тоть бусдыгаа удирдан өөр модонд нүүн очно. Дараагийн өдөр ухаант тотийн үгэнд эс орсон тул баригдана. Үхсэн мөртлөө амилдаг үнэхээрийн муу ёрын шувууд байна. Энэ үлдсэн ганцыг нь үхлийн муугаар алья гээд баян тотийн өд сөдийг нь зумлаж, хог дээр хаяна.

Мэргэн тоть ухаан ороод шаазгай, хэрээ хоёроор дамжлуулан, баяны гэрт бурхны гүнгэрвааны нь ард орж, бурхны дүрээр дуугаран, хоол унд идсээр биеэ тэнхрүүлнэ. Тоть, баяныг буцалсан усаар гэгзгээ зумлаж, арзгар хадаар хуйхаа хусвал биеийг чинь өршөөж, адуу малыг чинь үлдээе. Эс тэгвэл тэнгэр ниргэнэ гэж бурхан айлдаж байгаа байдлаар далдаас ярьж үнэмшүүлэн, өшөөгөө авч, нисэн одно.

Дээр өгүүлсэн: А. "Уран тоть шувуу"
 Б. "Далан тотийн үлгэр"
 В. "Мэргэн тоть шувуу"

хэмээх аман үлгэрийг ажиглахад ижил ба ялгаатай тал олон байна. Үүнд хүний хэлээр өгүүлэгч тотийн дүр гурван хувилбарт ижил байна.

- А. Өнгөрсөн 99 жилийн өмнөхийг тоолон мэддэг, ирэх 99 жилийн юмыг зөгнөн мэддэг шувууны хаан ухаант уран тоть
- В. Ухаант халзан тоть
- С. Мэргэн тоть гэж дүрслэгдсэн.

Тоть шувууг барих мотив:

- А. Хааны нүд сохроход 71 тотийн аль нэгний нь тархийг идвэл хараа орно гэж мэргэн зурхайч хэлсэн

- Б. Хатанг өвдөхөд 70 тотийн тархи ид гэж эмч хэлсэн
- С. 71 тотийг хөөхгүй бол үгүйрнэ гэж лам хэлсэн тул

Тотийг хэн хаанаас барих нь:

- А. 13 настай гуйлгачин хүү газар тэнгэрийн савсалганаас
- В. Ядуу урхич өвгөн хадан хавцгайгаас
- С. Баян гэрийнхээ ойр орших модноос

Ямар аргаар тотийг барьж ирэх нь:

- А.Тороор В. Урхиар С. Хялгасаар тор сулжиж

Тотиудыг алдах мотив:

- А. Үхсэн байсан шувуудыг хүү тоолон шидлэх үед билүү газарт унахад тотинууд тоонд авч, зэрэг нисэхэд цэцэн тоть ганцаар баригдана.
- В. Өвгөний бүсэндээ хавчуулаастай шийдэм нь унасан тул
- С. Баяны бүсэнд хавчуулаастай сүх нь унасан тул

Баригдсан тотийн амиа аварсан нь:

- А. Баян хаанд өөрийгөө 800 алтан зоосноос худалдаж, азарган тахианы тархи хаанд идүүл гэж хүүд хэлнэ.
- В. Өөрийгөө 100 лангаар худалдаж, 70 лангийн нь өрөнд, 30 ланг нь өөрөө ав гэж өвгөнд хэлнэ.
- С. Үг хэлээгүй.

Тотийн өгүүлэх хажлагын хэлхээс үлгэр нь:

- А. Аа "Тотийн үлгэр" хатныг саатуулж үлгэр ярина.
- А. б. "Сарангэрэл, Нарангэрэл хоёрын үлгэр"
- А.в. "Савсаг эхнэрийн үлгэр"
- А.г. "Ачитнаа хорлосон тухай үлгэр"
- В. Тодорхой үлгэр өгүүлэхгүй.
- С. Тодорхой үлгэр өгүүлэхгүй.

Тотийн амиа аварсан нь:

- А. Муур, хулганатай нөхөрлөн, бурхны хайрцагны ард хоньсам бодисадын дүрээр өгүүлж, биеэ тэнхрүүлнэ.
- В. Ийм үйл явдал байхгүй.
- С. Хэрээ, шаазгайтай нөхөрлөн, гүнгэрваатай бурхны ард амилсан бурхны дүрээр хонины шүүс өргүүлнэ.
- А, С үлгэрт хаан, хатан, баянаас үс ноосоо зулгаалгаж, өд сөдөө хугалуулсныхаа өшөөг авах нь ижилхэн байна.
- А хувилбарын зохиомж, мотив нь Энэтхэгийн Шукасабти зохиолтой адил төстэй байна.

Аман хувилбарын хажлага (жаазлан өгүүлсэн) үлгэрүүдийг бичгийн хувилбартай харьцуулан ажиглав.

"Арж Борж хааны намтрын 8-р бүлэг "Далан нэгэн тотийн үлгэр"-ийн "Наран охин ба Саран түшмэлийн үлгэр" нь монгол, аман "Сарангэрэл, Нарангэрэл хоёрын үлгэр"-тэй төстэй байна.

Бичгийн хувилбарт хүнд огт харуулдаггүй Наран охиныг Саран түшмэл өөрөө саваагүйтэн хулгайгаар хардаг бол аман үлгэрт Нарангэрэл гүнжийг Сарангэрэл түшмэлийн эхнэр ятгаж нууцаар

харуулсан зэрэг зөрөөтэй дүрслэл цөөнгүй байна. Энэ дүрслэлээс А хувилбар шидэт үлгэрийн шинжтэй болжээ. Сарангэрэлийн эхнэр хурмастын охин, түшмэлд туслахаар ирсэн.

Хаан заргын арвайгаар хэрэг шүүх зэрэг шидэт дүр, эд юмс дүрслэгдэнэ. Ийнхүү аман хувилбар нь бичгийн зохиолыг ихээхэн боловсруулсан, хэл найруулга, дүрслэлээрээ бүхэлдээ монгол аман үлгэрийн онцлог шинжийг хадгалжээ.

А хувилбарт:

Тоть "өнгөрсөн 99 жилийн өмнөхийг тоолон мэддэг ирэх 99 жилийн юмыг зөгнөн мэддэг", үлгэр ярихад "дээд гучин гурван хурмаст тэнгэр, доод далдын баян далан долоон лусын хаад, уул усны хувилгаад газар лусын савдаг тэр бүхэн ирж таалан сонирхдог учир та хаан хүний хатан болохоор утаагүй улаан галаа түлж, уургүй улаан цайгаа чанаад гэр орноо цэвэрлэж, бурхан тахилаа арчиж, өмнөө аягатай цайгаа тавиад ямбаныхаа ширээн дээр хаан хүний хатан шиг суувал үлгэр ярина гэж тэр тоть хэлж байгаа, Нарангэрэл дагина гэдэг бол наашаа харахад нь нар мишээж, цаашаа харахад нь сар гэрэлтэж байдаг хорвоо ертөнцөд хосгүй үзэсгэлэн гоо охин юмсанж.

Сарангэрэл түшмэл гэдэг харз усанд өрөм тогтоодог, хад чулуунаас үг хэлүүлдэг хааны бүх хэргийг явуулдаг хэрсүү сайн түшмэл байжээ. Богино жолоотой бүсгүй хүн гэдэг чинь их дээгүүр юм боддоггүй юм гэж түшмэлийн гэргий хэлэх, түшмэл сүх далайтал үхэр амар гэж бодоод хэвтэж байсан чинь дороо унтчихаж байгаа, гэргий нь Сарангэрэл түшмэлд дээл өмсгөж, бүсийг нь бүсэлж өгөх, хэт хутга, гаанс тамхины хэрэглэл, хөөрөг даалин зэргийг нь зүүж чимэх, шөнө хугархайд нойр алдах, нүд дүүрэн эр хүн, хаан мэл гайхаж цэл хөхрөв гэх мэт монгол ардын тууль, үлгэрийн яруу хэллэг, дүрслэл, монгол хэлний өвөрмөц үг, монгол зан үйл, ёс заншил, угсаатны зүйд холбогдох дүрслэлээр дүр бүтээсэн байна.

Үлгэрийн баатрууд Галбадрах, Нарангэрэл, Сарангэрэл, Мөнхбадрах гэсэн бэлгэдэл бүхий монгол нэртэй байна.

Ийм дүрслэл нь уг үлгэр яах аргагүй монгол ардын аман зохиол болохыг гэрчилж байна.

А.б. "Савсаг эхнэрийн үлгэр"

Энэ үлгэр монгол "Арж Борж хааны намтар"-ын "Бигармижид Наран дагиныг авсан нь" үлгэртэй төстэй байна. Тэр үлгэрт эр эм хоёр хөдөө явж байлаа. Гэтэл эр хүний сайхан дуу холоос сонсдов. Эхнэр нь тэр хүнд тачааж, эр нөхрөө худагт унагааж алаад дуу гарсан газар эрж очвол нэгэн өвчинд баригдсан хүн байна. Тэр эм өвчтэй эрийг үүрч явсаар хатаж үхсэн гэнэ. Тэр сайн эм үү? Муу эм үү? гэсэнд зул өгүүлрүүн:

Өвчит эрийг сайн арчилсан бол сайн эм мөн гэв. Наран дагина тэсэхгүй болж "Эрээ алсан эм яагаад сайн байх вэ?" гэв. Наран дагиныг

хоёр удаа дуу гаргасны учир Бигармижид хатнаа болгон аваад таван зуун залуусыг суллан тавина⁵.

Энэ хувилбарт хүний сайн, муу зан чанарыг үзүүлж, сонсогчоос хариулт шаардсан, Наран дагиныг дуугаргах зорилготой байна.

Тэгвэл аман хувилбарт монгол ардын гэм нь урдаа, гэмшил нь хойноо гэдэг цэцэн үгийн утгыг тайлж, тусыг усаар хариулахгүй байхыг сануулж, анхааруулсан үүрэгтэй байна.

Бичгийн хувилбарт тэр эм өвчтэй эрийг үүрч, тодорхой хугацаагаар энэрч асарсан боловч хатаж үхэж байна. Нүгэл буяныг номлосон шашны уран зохиолд ийнхүү дүрслэх нь аргагүй. Аман үлгэрт зовж чарлаж байгаа хүнийг үзэсгэлэнт эр хэмээн андуурсан саваагүй эм сэтгэлээр унаж, галзууран хад руу нисч үхэж байна.

Ингэж нүгэл буяныг үл мэдэгч, өөрийгөө өгүүтгэгч нүгэлт эмийн дүр нь бичгийн зохиолын адил дүрээс ялгарч, бичгийн үлгэрийн шашны сургаалын үзэл санааг өөрчлөн, иргэний сургаал болгон хувиргасан байна.

А.с. Ачитнаа хорлосон тухай үлгэр (Аа. Т. 178А)

Аюулаас хэн нэгнийг тухайлбал эзнээ юмуу нялх хүүхдийнх нь амийг аварч тус болох гэсэн биш харин сэрэмжгүй мунхаг, хар хор ихт хүнд өөрийгөө хорлуулсан муур, хулгана, нохой, тоть, хэрээ зэрэг амьтдын үхлийн тухай мотив Энэтхэг, Төвд, Монгол аман ба бичгийн зохиолд түгээмэл байдаг.

Рашааны дуслын төвд тайлбар Шидэт хүүрийн үлгэрийн бичгийн, монгол хувилбарын 16-р бүлэг "Өнгөт наран хатны үлгэр", Шидэт хүүрийн аман хувилбар, Монгол ардын "Дөрвөн түшмэлтэй хаан" зэрэг үлгэрт ийм мотив байдаг. Дээр өгүүлсэн Уран тотийн үлгэрийн Ачитнаа хорлосон үлгэр аман ба бичгийн зохиолоос эхтэй үлгэр байна. Гэхдээ Энэтхэг, Төвд зохиолын өгүүлэмжтэй адил төстэй боловч дүрийн хувьд элсэн цөлд баатар эр ангаж яваа, амь аврагч ачтан нь суурин газрын муур, хулгана, тоть биш цөл талын хэрээ байна. Хэдийгээр хэрээ хаана ч байдаг боловч монгол хүн хон хэрээг хүний нүд ухдаг гэрийн ойр орчинд хэрээ гуаглавал муу ёр хэмээн сэжиглэдэгтэй холбон үзвэл сайхи хэрээг сэжиглэсэндээ яаран алсан нь үнэмшилтэй, учир шалтгаан бүхий дүрслэл болсон байна.

В. Далан нэгэн тотийн үлгэр (Аа. Т 223в)

Энэ үлгэр Далан тотийн үлгэрийн торонд баригддаг шувууны мотивт хамаарагдана. Ийм үлгэр монголд аман хувилбараар өргөн дэлгэрч байсны нотолгоо болж буй нь ардын билиг зүйд ач холбогдолтой юм.

Харин үйл явдал нь бүрэн бус, тотийн өгүүлэх хажлагын үлгэр байхгүй байна. Уг аман үлгэр Монгол Арж Борж хааны намтарын 8-р бүлэг Далан нэгэн тотийн үлгэрийн эхлэлийн хэсэгтэй их адилхан байна.

⁵Монголын уран зохиолын тойм 1976., 313.

Бичгийн хувилбарт ухаант тоть “Модонд жиг ургав, модонд хоноё” гэхэд бусад нь “Чамд жиг орсон биз” гээд үгэнд нь эс орон баригддаг бол аман хувилбарт ухаант халзан тоть “Хоногийн газар жиг ургав” гэхэд бусад нь “Чи дандаа хоногийн газар жиг ургаж гэж хэлж олон жил амьдарсан газраас салгалаа. Чиний хар толгойд жиг ургаж” гэж хэлээд үгэнд нь эс орон баригдаж байна. Үлгэрийн төгсгөл нь В хувилбарт тотийг нэг хааньд 100 лангаар худалдаж, 71 лангаар шувууны тархи авч хаандаа барьж, үлдсэн цөөн мөнгийг өөрөө авч байна. Тоть баяны эхнэрийг саатуулахдаа Наран охин ба Саран түшмэлийн үлгэрийг өгүүлнэ.

Энэ мэт бага сага зөрөөтэй дүрслэл байгаа боловч уг үлгэр аман хувилбараар халх, буриад зэрэг монгол үндэстний дунд өргөн дэлгэрч байсан, одоо ихээхэн мартагдаж буйг харуулж байна.

С. Мэргэн тоть шувуу

Ордосын энэ үлгэр А,В хувилбараас их өөр байна. Ямар нэг хаан, хатан сохор нүдээ, өвчнөө эдгээхэд тотийн тархи сайн тул хэн нэгнийг тоть шувууг бариулахаар алс хол явуулах мотив А, В хувилбарт тогтвортой байна. Гэтэл С хувилбарт тэр мотивийг хэрэглэлгүй өөр хувилбар сонгожээ. Баяны гэрийн ойр элдэв зүйлийн мод ургасан “Модтой газар шувуутай” гэгчээр тэр олон модонд 71 тоть үүрлэдэг. Гэр орон хүн малын ойр байж дассан тоть тоонон дээр сууж л байдаг бололтой. Харин үүнийг харсан лам:

“Тоть шувуу

Тоонон дээр чинь суу

Тоот малыг чинь хулгай дага” гэж байна хэмээн шувууны хэлийг мэдэгч болон хэлсэн үг тоть шувууг А,В хувилбарынх шиг тотийн тархийг эм домын ёсоор хэрэглэх биш харин бүр шууд алах аюулд хүргэж байна.

Баяныд гүрэм хийж суугаа ламын тийнхүү хэлсэн үг үнэн бол хараалын үг тул баян сэжиглэх нь аргагүй байна. С хувилбарт ламын (А, В хувилбарт байхгүй) дүр нэмэгдэж, тэр лам гэр орчмынхоо тотийг зайлуул гэж баянд хэлж байгаа үг, бичгийн ба А,В-д дахин давтагддаг мотивыг өөрчилж, С зохиолын үзэл санаа ч өөрчлөгдөн хувирч байна.

А хувилбарт тотийн үгийг үл ухаарагч хаан, хатны гэмийг шүүмжилж гэм нь урдаа гэмшил нь хойноо хэмээх мэргэн үгийн утгыг тайлсан шинжтэй бол В хувилбарт бурхан шашин лам хувраг хүнийг элэглэсэн өнгө аястай болжээ.

Ийнхүү Далан тотийн үлгэрийн зохиомж, дүр мотив, монгол ардын аман зохиолд нөлөөлсөн боловч монголчууд уг зохиолын үлгэрийг яг хуулан давтсангүй, харин ихээхэн боловсруулж, монголжуулж шинээр үлгэр зохиож, үндэстний зохиол болгон олон хувилбараар үе дамжуулан өгүүлсээр ирсэн байна.

Ном зүй

1. Ардын аман зохиолын эмхэтгэл. УБ. 1947, 6-11-ртал.
2. Банди Г. Үлгэрүүд. Улаангом, 1990.
3. Востриков А.И. Тибетская историческая литература. Москва 1962.

4. Гринцер П.А. Древнеиндийская проза (обрамленная повесть), Москва. 1963.
5. Гринцер П.А. Санскритская обрамленная повесть индийская средневековая повествовательная проза. Москва, 1989.
6. Дамдинсүрэн Ц. Ардыг тэжээхүй дусал нэрт шашдирын тайлбар Чандманийн чимэг. Улаанбаатар, (CSM Т. Fasc.2.) 1960.
7. Дамдинсүрэн Ц, Серебрянный С.Д. "Обрамленные повестив Индий и у монгольских народов". Литературные связи Монголии. Москва, 1981., стр 130-149.
8. Дашдорж Д. Сайхан хангайн дуулал. Булган. 1976., 176-177-р тал.
9. Ёндон Д. Төвд Монголын уран зохиолын харьцааны асуудалд. УБ. 1980.
10. Ёндон Д. Сказочные сюжеты в памятниках тибетской и монгольской литературы. Москва, 1989.
11. Индийская сказка. Перевод с языка урду М. И. Клягиной. 1958.
12. Кондратьевой и Крашенинникова. В. Л. Москва.
13. Индийская средневековая повествовательная проза. Москва. 1982.
14. Костюхин Е.А. Типы и Формы животного элоса. Москва. 1987.
15. Мелетинский Е.М. Историческая поэтика новеллы. Москва. 1990.
16. Монголын уран зохиолын тойм. Тотийн үлгэр. 2-р дэвтэр, редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд. Улаанбаатар. 1976.
17. Монгол ардын үлгэр (Монгол ардын аман зохиолын чуулган цуврал. Эмхэтгэсэн Д.Цэрэнсодном), 2-р боть. Улаанбаатар. 1982.
18. Семьдесят рассказов попугая. Перевод с санскрита М.А. Ширяева. Москва, 1960.
19. Пропп В.Я. Морфология сказки, Изд. 2-е, Москва, 1969.
20. Хорлоо П. Монгол ардын явган үлгэр. Улаанбаатар. 1960.
21. Хүрэлбаатар Л. "Б.Я. Владимирцовын судалгаа, Энэтхэг, Төвдийн утга зохиолтой холбогдол бүхий монгол зохиол", Хэл зохиол, 20-р боть, 21-25-ртал. Улаанбаатар. 1988.
22. Хүрэлбаатар Л. "Төвдөөр бичсэн сургаал үлгэрийн нэгэн цоморлиг". MONGOLIA AN INTERNATIONAL ANNUAL OF MONGOL STUDIES. VOL. 2(23), 2(24), Ulaanbaatar, The Secretariat of the International Association for Mongol Studies, 215-229-р тал.
23. Хүрэлбаатар Л. "Винайн эшийн цоморлиг ба монгол үлгэр". MONGOLIAN STUDIES. №5, Reprinted. The Korean Association for Mongol Studies. Seoul.
24. Цендина А. Д. "Монгольская новеллистика XYII-XIX вв, и Индо-тибетские традиций". Монгольская литература. (Очерки из истории XII - первой половины XX в) Сборник статей. Сост.К.Н Яцковская. Институт востоковедение РАН, Москва, стр 177-208.
25. Чүлтэмсүрэн Р. Аман ба бичгийн зохиолын харьцаа. (Шидэт хүүрийн үлгэрийн аман ба бичгийн хувилбарын жишээн дээр), Эрдмийн зэрэг горилсон зохиолын хураангуй. Улаанбаатар. 1997.
26. Элиасов Л.Е. Бурятские народные сказки. Изд 2-ое, Улан-Үдэ. 1973.
27. Robe S.L. "Index of Mexican Folktales, Including Narrative Texts from Mexico, Central America and Hispanic United States", Folklore Studies, Berkley-London, 1973, №26.
28. Damdinsurung Ce. Tobed mongol sidtu kegur-un uliger, CSM. Т.1,2 (Tibetan and Mongolian tales of Uetala) Улаанбаатар. 1962, 1964.
29. Degedu mongol-un uliger domog, Undusuten-u keblel-un qoriy-a. 1986.
30. Ordos-un aman uliger, Koke qota. 1990.
31. Mostaert A. Folklore Ordos. Peiping. 1947.
32. Mostaert A. Arji Borji qagan. (degedu debter) Undusuten-u keblel-un qoriy-a. 1989.